



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 06 өдөр

Дугаар А/196

Мандалговь

Г Аюулаас сэрэмжлүүлэн анхааруулах Г
Цогцолборын үйл ажиллагааг сайжруулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.11 дэх заалт, Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 239 дүгээр тушаалаар баталсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журмын 2.1.3 дэх заалт, Аймгийн Засаг даргын 2016 оны А/348 тоот захирамж, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2017 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 09 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Малчид иргэдийг орон нутгийн мэдээллээр хангах аюулаас сэрэмжлүүлэн анхааруулах цогцолборын өдөр тутмын хэвийн ажиллагааг хангуулах болон орон нутгийн мэдээллийн эх үүсвэрийг бэлтгэж байгаа Төрийн албан хаагчдын мэдээллийг архивлаж байх зорилгоор, хавсралтанд дурьдсан төхөөрөмжөөр хангаж зориулалтаар нь ашиглахыг аймгийн Онцгой байдлын газрын дарга, /Хурандаа Я.Алтанхундага/, Эрдэнэдалай сумын Засаг дарга /С.Мөнхбаатар/, Говь-Угтаал сумын Засаг дарга /Б.Доржсүмбэр/ нарт даалгасугай.

Хоёр. Хавсралтанд дурьдсан төхөөрөмж бусад зүйлсийг авахад шаардагдах зардал 1.200.500 /нэг сая хоёр зуун мянга таван зуу/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын тамгын газрын дарга /О.Чулуунбат/, нягтлан бодогч /Ц.Даваа/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



0200579